

Албан тушаалын тодорхойлолт



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 09 мөдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн бүтэц,
орон тооны дээд хязгаарыг батлах тухай


Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.1 дэх заалт, тус газрын даргын 2016 оны А/129, 2017 оны А/24, 2019 оны А/31 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын харьяа аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн орон тооны дээд хязгаарыг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвчийг хоёрдугаар хавсралтаар, Дархан-уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвчийг гуравдугаар хавсралтаар, Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвчийг дөрөвдүгээр хавсралтаар, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвчийг тавдугаар хавсралтаар, Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвчийг зургаадугаар хавсралтаар, Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн 2019 онд мөрдөх ажлын байр, албан тушаалын жагсаалтыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан цалингийн сандаа багтаан цаг агаарт зориудаар нөлөөлөх, тусгай хэрэгцээний мэдээ, мэдээллээр үйлчлэх, байгалийн гамшигт болон аюултай үзэгдэлтэй үед ажиллах, байнгын, тасралтгүй байх салбарын онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзан газрын генераторч, цаг уурын болон усны харуулын ээлжийн амралттай үеийн орлон ажиглагч, галч, слесарь, цахилгаанчин зэрэг төрийн үйлчилгээний зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхийг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2015 оны А/177, 2018 оны А/68, 2016 оны А/129 дугаар тушаалын 2, 3, 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН

БАТЛАВ
ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА С.ЭНХТҮВШИН
2020 оны 03 сарын 30 өдөр

**БУЛГАН АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2020 ОНД
МӨРДӨХ ОРОН ТОО АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	АЛБАН ТУШААЛ	Албан хаагчдын тоо	Албан тушаалын зэрэглэл
Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс / 8 хүн/			
1	Төвийн дарга	1	ТУ-11
2	Ахлах нягтлан бодогч	1	ТУ-8
3	АМД сангийн ерөнхий зохицуулагч	1	ТУ-8
4	ЦАЗНУ, ХХАА хариуцсан ерөнхий технологич инженер	1	ТУ-8
5	Хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтан	1	ТУ-7
6	Аж ахуйн нярав	1	ТУ-4
7	Механик, жолооч	1	ТУ-5
8	Үйлчлэгч	1	ТУ-1
Цаг уур, орчны технологийн хэлтэс / 66 хүн/			
9	Хэлтсийн дарга бөгөөд хэмжих хэрэгсэл хэмжлийн технологи хариуцсан ерөнхий технологич инженер	1	ТУ-10
10	Цаг уур, уур амьсгалын салбар хариуцсан ерөнхий технологич инженер	1	ТУ-8
11	ХАА-н цаг уурын ерөнхий технологич инженер	1	ТУ-8
12	Гадаргын ус судлалын салбар хариуцсан ерөнхий технологич инженер	1	ТУ-8
13	БОШЛабораторийн ерөнхий инженер	1	ТУ-8
14	БОШЛабораторийн технологич инженер	1	ТУ-8
15	Цаг уур, уур амьсгалын ахлах техникч	2	ТУ-7
16	ХААЦУ-ын ахлах техникч	1	ТУ-7
17	Гадаргын ус судлалын өртөөний ахлах техникч	1	ТУ-7
18	Цаг уурын өртөөний дарга	6	ТУ-7
19	Өртөөний техникч	24	ТУ-6
20	БОШЛ-ийн техникч	1	ТУ-6
21	Цаг уурын харуулын ажиглагч	10	ТУ-6
22	Ус судлалын харуулын ажиглагч	12	ТУ-6
23	МАНЦУ-ын харуулын ажиглагч	3	ТУ-6
Мэдээлэл үйлчилгээний хэлтэс / 8 хүн /			
24	Хэлтсийн дарга бөгөөд урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич	1	ТУ-10
25	Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер	4	ТУ-8
26	Систем сүлжээний ерөнхий инженер, автомат станц хариуцсан инженер	1	ТУ-8
27	НЦУС-ын техникч	1	ТУ-6
28	Сүлжээний техникч	1	ТУ-6
Гэрээт ажилчид / 10 хүн /			
29	Агро цаг уурын харуулын ажиглагч	1	ТУ-1
30	Ус судлалын харуулын ажиглагч	4	ТУ-1
31	Галч	4	ТУ-2
32	Сахиул	1	ТУ-1